

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн АШУУИС- Говь-Алтай аймаг салбар анагаах ухааны сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2024/238НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Алтай хот

2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа

Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn

Ахлах аудитор: Э.Сүнжидмаа

Утас: 80048599 Цахим хаяг: Sunjidmaae@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт /Баталгаажсан хувийг оруулах/

ГАА-2024/40/НА-СТА-ТШЗ



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.23 № 74

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 8.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу АШУҮИС-ийн Говь-Алтай аймаг дахь салбар Анагаах ухааны сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

АШУҮИС-ийн Говь-Алтай аймаг дахь салбар Анагаах ухааны сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус сургууль нь 2023-2024 оны хичээлийн жилд Боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөлөөр "Эх барихуй"-н мэргэжлийн хөтөлбөр, сувилахуйн бакалаврын хөтөлбөрийг тус тус магадлуулсан, "International Medical Science Conference-V" Олон улсын хурлыг зохион байгуулсан байна.

Аудитын гол асуудал

Өмнөх оноос өглөг 111,130.6 мянган төгрөгөөр, авлага 235,221.1 мянган төгрөгөөр тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 3 зорилт 21 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас АШУҮИС-ийн Хяналт шинжилгээ, үнэлгээ дотосд аудитын газраас 96.3 хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

0702900284

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П. ГҮНЖИДМАА

АШУУИС-ийн Говь-Алтай аймаг дахь салбар анагаах ухааны сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл /мян.төгрөгөөр/

Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	1,599,957.2	1,002,634.3
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	6,723,369.3	6,521,146.6
Нийт хөрөнгийн дүн	8,323,326.8	7,523,780.9
Нийт өр төлбөрийн дүн	759,702.7	648,571.8
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	7,563,624.1	6,875,209.1
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	8,323,326.8	7,523,780.9
Үйл ажиллагааны орлогын дүн	2,408,871.5	2,353,640.2
Үйл ажиллагааны зардлын дүн	2,928,956.4	3,045,656.1
Үйл ажиллагааны үр дүн	(520,084.8)	(692,016.9)
Үйл ажиллагааны бус үр дүн		
Үйл ажиллагааны нийт үр дүн	(520,084.8)	(692,016.9)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,958,514.9	7,563,624.1
Тайлант оны үр дүн	(520,084.68)	(692,015.9)
Эцсийн үлдэгдэл	7,563,624.1	6,875,209.1
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	2,911,264.0	2,456,965.6
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	2,621,856.1	2,764,542.5
Үйл ажиллагааны ЦМГ	(289,407.9)	(307,576.8)
Хөрөнгө оруулалтын ЦМГ	109,796.7	104,752.8
Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	179,614.2	(412,245.6)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	398,631.1	578,245.3
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	578,245.3	165,915.6
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	3,234,270.3	2,869,295.3
Урсгал зардал	3,234,270.3	2,869,295.3
Хөрөнгийн зардал		
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	3,028,568.3	2,288,248.9
Улсын төсвөөс санхүүжих		
Орон нутгийн төсвөөс санхүүжих		
Үндсэн үйл ажиллагааны орлого	3,028,568.3	2,288,248.9


Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 21,439.3 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдааг аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Санхүүгийн үр дүнгийн тайланд урсгал зардлыг 13,458.6 мянган төгрөгөөр зардлыг зөрүүтэй тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг

ГАА-2024/40/НА-СТА-ТШЗ



баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" гэсэн заалтыг зөрчсөн байна

- **Хууль тогтоомжтой холбоотой:** Бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөрийн дүн татварын нэвтрэлтийн нэгдсэн системд 7,980.9 мянган төгрөгийн гүйлгээг дутуу шивсэн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.1-т Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно/ гэсэн заалтыг зөрчсөн байна

Залруулагдаагүй нийт 2,031.0 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" санал дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 2,031.0 мянган төгрөгийн 3 зөрчил илэрч, 2 зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн байна.

5.1 Албан шаардлага

1. Нийгмийн даатгалын хэлтэст 2,031.0 мянган төгрөгийн цалинг дутуу тайлагнасан нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.1-т Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно/, Нягтлан бодох Цалингаас суутгах хүн амын орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэл, хуулийн дагуу олгодог бусад нэмэгдэл, тэтгэмж, тусламжийг цалингийн системд зөв оруулж байх зорилгын үүднээс эдгээртэй холбоотой хууль эрх зүйн актын жагсаалтыг бүрдүүлэх" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цалинг нийгмийн даатгалын хэлтэс нөхөн тайлагнах албан шаардлага хүргүүлсэн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Ээлжийн амралтын хоногийн тооцохдоо багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалт, листтэй байсан хоногийг хасаж ээлжийн амралтын хоногийг бууруулан тооцсон байна. Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно.", Тухайн цалин, нэмэгдэл тогтоосон эрх бүхий байгууллагын шийдвэрийг нэмж тусгана. Хөдөлмөрийн тухай хуулийн 110 дугаар зүйлийн 110.1-т "Ээлжийн амралтын цалинг ажилтны тухайн ажлын жилийн дундаж цалин хөлснөөс тооцож олгоно", Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/19 дүгээр тушаалын хавсралтын 3 дугаар зүйлийн 3.4-т "Ээлжийн амралтын цалинг тооцохдоо өмнө эдэлсэн ээлжийн амралтаас хойш ажилласан саруудын цалин хөлсний нийлбэрийг, тухайн саруудад ажилласан ажлын өдрийн нийлбэр тоонд хуваан ажлын нэг өдрийн дундаж цалин хөлсийг гаргаж ээлжийн амралтын өдрөөр үржүүлж бодно" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ажилчдын ээлжийн амралтын хоногийн тооцоог үнэн зөв тооцож байх

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

		/мянган төгрөгөөр/															
Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Залруулсан		Залруулаагүй		Зөвлөмж					
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
		3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14				
1	2																
АШУУИС-ийн Говь-Алтай аймаг дэхь Анагаах Ухааны Сургууль	Санхүүгийн үр дүнгийн тайланд урсгал зардлыг 13,458.6 мянган төгрөгөөр зардлыг зөрүүтэй тайлагнасан байна. Бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөрийн дүн татварын нэвтрэлтийн нэгдсэн системд 7,980.9 мянган төгрөгийн гүйлгээг дутуу шивсэн.	1	13,458.6	-		1	13,458.6	1	13,458.6								
		1	7,980.7	1	7,980.7			1	7,980.7								
	Дүн	2	21,439.3	1	7,980.7	1	13,458.6	2	21,439.3	-	-	-	-	-	-	-	-

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:									
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн			
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12		
АШУУИС-ийн Говь-Алтай аймаг дахь Анагаах Ухааны Сургууль	Нийгмийн даатгалын хэлтэст 2,031.0 мянган төгрөгийн цалинг дугуу тайлагнасан байна. Эзлэгийн амралтын хоногийн тооцохдоо багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалт, листтэй байсан хоногийг хасаж эзлэгийн амралтын хоногийг бууруулан тооцсон байна.	1	2,031.0	-	-	1	2,031.0	-	-	-	-		
Нийт		2	2,031.0	-	-	1	2,031.0	-	-	-	-		

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:									
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
1	2	3	4	5	6	7	8	9	10				
АШУУИС-ийн Говь-Алтай аймаг дахь Анагаах Ухааны Сургууль	Шилэн дансанд байршуулах цалингийн зардлаас дээш нийт орлогын 59,000.0 мянган төгрөгийн 1 гүйлгээ, 5 саяас дээш зарлагын 128,862.6 мянган төгрөгийн 12 гүйлгээг хугацаа хоцорч мэдээлсэн байна.	1	-	-	-	1	-	-	-				
дүн		1	-	-	-	1	-	-	-				